

Улсын нэгдсэн бүртгэлийн 2014...оны 01...р  
оффин.07 -ны өдрийн 3.02 дугаарт бүртгэв.  
Монгол Улсын Хууль зүйн яам

МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

Г 7  
Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.12 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Ерөнхий гэрээ байгуулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, ерөнхий гэрээний маягтыг хоёрдугаар хавсралтаар, ерөнхий гэрээний судалгааны жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж, улирал тутам тайлагнаж ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар /Д.Энхжаргал/-т журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/-т тус тус даалгасугай.

САЙД

Ч.УЛААН

Ч.УЛААН

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ	
ХУУЛБАР ҮНЭН	
Бүртгэлийн №....15...	
Төрийн захирагааны удирдлагын газрын дарга	
Архивын эрхлэгч ..... 	
Нийт ... хуудас	2014 он 1 сар 9 өдөр

000697

Сангийн сайдын 2013 оны 9 дүгээр сарын  
25-ны өдрийн 213 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

## ЕРӨНХИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан /цаашид “хууль” гэх/ бараа, ажил, үйлчилгээг ерөнхий гэрээ байгуулан худалдан авахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Захиалагч ерөнхий гэрээ байгуулан бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

### Хоёр. Нэр томъёо

2.1 Энэхүү журамд заасан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 2.1.1. “Мэргэжлийн байгууллага” гэж хуулийн 53.1-д заасан үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Худалдан авах ажиллагааны газрыг;
- 2.1.2. “Худалдан авалтын захиалга” гэж захиалагч байгууллагаас ирүүлж буй худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээг;
- 2.1.3. “Ерөнхий гэрээ” гэж хуулийн 5.1.23-т заасныг;
- 2.1.4. “Цахим дэлгүүр” гэж Ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл бүхий Цахим худалдан авах ажиллагааны системийн бүрэлдэхүүн хэсгийг.

### Гурав. Ерөнхий гэрээ

- 3.1. Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээг хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу тендерийн баримт бичгийг боловсруулан цахим хэлбэрээр зохион байгуулна.
- 3.2. Мэргэжлийн байгууллага нь энэхүү журмын 6.1-т заасны дагуу зохион байгуулсан тендер шалгаруулалтад “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн нэг болон түүнээс дээш нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгчтэй З хүртэл жилийн хугацаанд унэ болон бусад нөхцлийг тохирч ерөнхий гэрээ байгуулна.
- 3.3. Ерөнхий гэрээг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу холбогдох жишиг баримт бичгийн гэрээний нөхцөлөөр байгуулна.

- 3.4. Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээг Цахим худалдан авах ажиллагааны системийн “Цахим дэлгүүр” хэсэгт байршуулна.
- 3.5. Ерөнхий гэрээнд гэрээний хэрэгжих хугацаа, захиалгын нөхцөл, үнэ болон бусад шаардлагуудыг тодорхойлж, бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарь, захиалагчаас ирүүлсэн бараа захиалгын хуудас зэргийг хавсаргана.
- 3.6. Ерөнхий гэрээнд заасан үнэ гэрээний үндсэн үнэ байх бөгөөд гэрээний хүчинтэй хугацааны турш тогтмол байна. Зөвхөн хуулийн 40.4-т заасан нөхцөл үүссэн үед гэрээнд үнийн тохируулга хийж болох бөгөөд энэ нь хуулийн 41 дүгээр заалттай нийцсэн байна.
- 3.7. Захиалагч нь ерөнхий гэрээний дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээг Цахим худалдан авах ажиллагааны системийн “Цахим дэлгүүр” хэсэгт байршуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгч этгээдүүдээс ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай, өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмыг үндэслэн сонгож, худалдан авна.

#### **Дөрөв. Мэргэжлийн байгууллагын үүрэг**

- 4.1. Хуулийн 45.5-д заасан худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тухайн төсвийн жилд ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг нэгтгэн төсвийн асуудал эрхлэх төрийн захиргааны төв байгууллагад, улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор Засгийн газарт тус тус хүргүүлнэ.
- 4.2. Мэргэжлийн байгууллага нь энэхүү журмын 4.1-д заасан жагсаалтад багтсан Ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг жагсаалт батлагдсан даруйд эхлүүлнэ.
- 4.3. Мэргэжлийн байгууллага нь ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ
  - 4.3.1. Ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бараа, ажил, үйлчилгээг тодорхойлох, энэхүү журмын 3 дугаар хавсралтаар батлагдсан судалгааг жил бүрийн 3-р улиралд багтаан шинэчлэн хийх;
  - 4.3.2. Захиалагч байгууллагын шаардлага болон нийлүүлэгчдийн чадварыг энэхүү журмын 4.3.1-т заасан судалгаанд үндэслэн тогтоох;
  - 4.3.3. Ерөнхий гэрээний үргэлжлэх хугацаа болон нэг гэрээнд байх нийлүүлэгчдийн тоог тогтоох;
  - 4.3.4. Ерөнхий гэрээг боловсронгуй болгон сайжруулах санал боловсруулж, Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
  - 4.3.5. Ерөнхий гэрээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлэх, гүйцэтгэгчийг сонгох, ерөнхий гэрээ байгуулах;

- 4.3.6. Энэхүү журмын З дахь заалтад заасны дагуу байгуулсан Ерөнхий гэрээний худалдан авалтын захиалгыг цахим хэлбэрээр хийх нөхцлийг бүрдүүлэх;
  - 4.3.7. Нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгчид нь холбогдох шаардлагын дагуу гэрээ гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавих;
  - 4.3.8. Худалдан авалтын захиалгын дүн захиалагч байгууллага бүрийн хэрэглээний тоо хэмжээтэй тохирч байгаа эсэхэд хяналт тавих;
  - 4.3.9. Шаардлагатай тохиолдолд гэрээнд хуулийн 40.4 дэх хэсэгт заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг хүчингүй болгох;
  - 4.3.10. Ерөнхий гэрээний хэрэгжилт болон үр дүнгийн тайланг гаргах маягтыг боловсруулж, тус маягтын дагуу тайланг нэгтгэн улирал бүр Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээллэх;
  - 4.3.11. Худалдан авалтын захиалгыг цахим хэлбэрээр хийх зааврыг боловсруулж, Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, мөрдөх.
- 4.4. Мэргэжлийн байгууллага нь энэхүү журмын дагуу ерөнхий гэрээ байгуулах талаар олон нийтэд сургалт, сурталчилгаа хийж, холбогдох мэдээллээр хангаж ажиллана.

#### **Тав. Захиалагч байгууллагын үүрэг**

- 5.1. Захиалагч байгууллагууд ерөнхий гэрээ байгуулах хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
  - 5.1.1. Энэхүү журмын 4.3.1-д заасны дагуу Мэргэжлийн байгууллагаас хийх судалгаанд хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээг үндэслэлтэй тодорхойлж, мэргэжлийн байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 1-ны дотор хүргүүлэх;
  - 5.1.2. Худалдан авалтын захиалгыг цахим хэлбэрээр Мэргэжлийн байгууллагын баталсан зааврын дагуу хийх;
  - 5.1.3. Худалдан авалтын захиалга хийх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг батлагдсан эсэхийг шалгасан байх;
  - 5.1.4. Худалдан авалтын захиалгын хуудсанд заасан тоо хэмжээ нь шаардагдаж буй хэрэгцээг хангаж байгаа эсэхийг няглан, баталгаажуулсан байх;
  - 5.1.5. Гэрээний дагуу хүлээн авсан барааг чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж турших, “Цахим дэлгүүр”-т холбогдох үнэлгээг өгөх, холбогдох төлбөрийг саадгүй гүйцэтгэх;
  - 5.1.6. Ерөнхий гэрээний хэрэгжилт болон үр дүнгийн тайланг батлагдсан маягтын дагуу улирал бүр Мэргэжлийн байгууллагад тайлагнах.
- 5.2. Захиалагч ерөнхий гэрээ байгуулан худалдан авахаар тодорхойлсон бараа, ажил, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр эх сурвалжаас худалдан авахыг хориглоно.

- 5.3. Нэг удаа хийгдэх захиалгын үнэ хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн дээд хязгаараас хэтрэхгүй байна.
- 5.4. Цахим дэлгүүрт зөвхөн ганц нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгч байх тохиолдолд шууд сонголт хийх бөгөөд бусад тохиолдолд нэгж үнэ, нийлүүлэх хугацаа болон бараа нийлүүлэлтийн хуваарь, энэхүү журмын 3.7-д заасан зарчмыг үндэслэл болгон сонгоно.

### **Зургаа. Ерөнхий гэрээний сонгон шалгаруулалт**

- 6.1. Мэргэжлийн байгууллага нь ерөнхий гэрээнд хамрагдах гүйцэтгэгчийг хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэн, Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 07 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулна.
- 6.2. Ерөнхий гэрээ байгуулсан оролцогчдын нэр, барааны зураг, гэрээний дугаар, бараа нийлүүлэлтийн хуваарь, нэгж үнэ, нийлүүлэх хугацаа, барааны гарал үүсэл, барааны тэмдгийг Цахим дэлгүүрт байршуулна.
- 6.3. Ерөнхий гэрээний хүчин төгөлдөр хугацаанд шинээр нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгчийг энэхүү журамд заасны дагуу тендер шалгаруулалт зарлан нэмж оруулж болно.

### **Долоо. Гэрээг цуцлах**

- 7.1. Дараахь тохиолдолд мэргэжлийн байгууллагын шийдвэрээр гэрээг цуцалж болно.
  - 7.1.1. Гэрээний хүчин төгөлдөр хугацаанд 3 буюу түүнээс дээш удаагийн худалдан авалтын захиалга хийхэд гүйцэтгэгч ажлын 5 хоногт хариу өгөөгүй;
  - 7.1.2. Захиалагч байгууллага нь нийлүүлэгчтэй үгсэн хуйвалдсаныг эрх бүхий этгээд тогтоосон;
  - 7.1.3. Нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгч нь ерөнхий гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;
  - 7.1.4. Ерөнхий гэрээ нь бодитойгоор хэрэгжихгүй байгаа нь тогтоогдсон ;
  - 7.1.5. Гэрээнд заасан бусад.
- 7.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

Сангийн сайдын 2013 оны 9 дүгээр сарын ...-ны  
өдрийн 22 дугаар тушаалаар батлагдсан  
“Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын  
Хоёрдугаар хавсралт

## ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### БАТЛАВ.

#### ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

#### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

### [Тендер шалгаруулалт/гэрээний нэр]-ЫН ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

Улаанбаатар хот

Нэг талаас **Худалдан авах ажиллагааны газар**, нөгөө талаас **[гүйцэтгэгчийн нэр]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 20... оны ... сарын ... -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу **[бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх, ажил гүйцэтгэх]** /аль тохирохыг сонгох/-тэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Худалдан авах ажиллагааны газар нь **[тендер шалгаруулалтын нэр]** гэх **[бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх, ажил гүйцэтгэх]** /аль тохирохыг сонгох/ тендер шалгаруулалтыг зохион байгуулж ..... **[нэгж үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний нэгж үнэ” гэх) төгрөгөөр захиалагч этгээдийн захиалгын дагуу гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв.
- Гүйцэтгэгч нь ..... нэр төрлийн **[бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх, ажил гүйцэтгэх]** /аль тохирохыг

сонгох/-г 20... оны ... дугаар сарын ... -нээс 20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн хугацаанд /гурав хүртэлх жилийн хугацаа/ гүйцэтгэнэ.

4. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>1</sup>;  
Тендер ба үнийн хуваарь;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

5. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан [бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх, ажил гүйцэтгэх] /аль тохиорохыг сонгох/- гүйцэтгэж, доголдол, дутагдлыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
6. Ерөнхий гэрээний нэгж үнэ нь өөрчлөгдөхгүй, тогтмол байна.
7. Энэхүү гэрээгээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг Цахим худалдан авах ажиллагааны системийн Цахим Дэлгүүр хэсэгт байрлах Захиалгын хуудсыг захиалагч бөглөн хүргүүлсний дагуу нийлүүлнэ.
8. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд нийлүүлэлтийн хуваарийг дагаж мөрдөнө.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд зөвхөн албан бичгээр харилцана.

**ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

<sup>1</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Сангийн сайдын 2013 оны 9 дүгээр сарын 21-ны  
өдрийн дугаар тушаалаар батлагдсан  
“Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын  
Гуравдугаар хавсралт

**Ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бараа, ажил,  
үйлчилгээг тодорхойлох судалгааны жагсаалт**

Худалдан авах ажиллагааны газар нь ерөнхий гэрээнд хамруулах барааг тодорхойлохдоо дараах судалгаануудыг хийж, түүний үр дунд үндэслэн “Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын 4.1-д заасны дагуу саналаа нэгтгэн боловсруулж Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

1. Эрэлтийн судалгаа хийх

- 1.1. Засгийн газрын нийт худалдан авалт буюу нийт эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүний ач холбогдлыг үнэлэх
- 1.2. Дээрх эрэлт хэрэгцээтэй уялдуулан нийлүүлэлтийн талаар судалгаа хийж, үүсэж болзошгүй хүндрэл, бэрхшээлийг тооцох
- 1.3. Ерөнхий гэрээнд хамруулах бараа, ажил, үйлчилгээний нэр, танилцуулга, техникийн тодорхойлолтыг гаргах

2. Оролцогч талуудын судалгаа

- 2.1. Захиалагч бүрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох
- 2.2. Нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийн чадавхийг тодорхойлох

3. Зах зээлийн судалгаа

- 3.1. Зах зээлийн бүтэц, өрсөлдөөний хэлбэр, хэмжээ, үнийн судалгаа
- 3.2. Хувилбарт барааны сонголтын талаар судалгаа хийх

4. Тухайн бараа, ажил, үйлчилгээг ерөнхий гэрээ байгуулан худалдан авахад үүсэх нөхцөлийг тодорхойлох “SWOT” шинжилгээ хийх

Дотоод хүчин зүйл	Хэрэгтэй (зорилгодоо хүрэхэд)	Аюултай (зорилгодоо хүрэхэд)
	Даевуу тал	Сул тал
Гадаад хүчин зүйл		

5. Ерөнхий гэрээ байгуулахтай холбоотой Эрсдлүүдийг тодорхойлох, эрсдлээс сэргийлэх төлөвлөгөө гаргах.

Эрсдэл	Боломж	Нэлөөлөл	Эрсдлыг арилгах, багасгах, хөнгөвчлөхөд шаардлагатай арга хэмжээ

--00o--